



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

XXXII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXXII дугаар хурал 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 14:30 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 97 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын онцгой комиссын даргын 2020 оны 19 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 08-ны өдрүүдэд Сэлэнгэ аймаг, хилийн Алтанбулаг боомтод ажилласан тухай

*Зам тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,*

2. Монгол, Оросын хилийн зарим авто замын боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох, хилийн Цагааннуур авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс нээх зохион байгуулалтын арга хэмжээний тухай

*Гадаад харилцааны сайд Н.Энхтайван*

3. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Барилга, хот байгуулалтын сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Мөнхбаатар,

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Улсын онцгой комиссын гишүүн С.Наранцогт,

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Анхбаяр,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий байцаагч

Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Гадаадын иргэн, харьяатын газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Ууганбаяр,

Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил,

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг

Улаанбаатар төмөр замын дарга Д.Жигжиднямаа,

Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим,

Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоонд:

1.1. Монгол, Оросын хилийн Алтанбулаг авто замын боомтоор хил нэвтрэх ачаа тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэл түр зогсоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

1.2. Хилийн Цагааннуур авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт хуваарийн дагуу ажиллуулж, зөвхөн шатахуун тээвэрлэх автомашиныг улсын хилээр нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах;

1.3. Хилийн Тэс, Арцсуурь, Ханх, Ульхан, Эрэнцав авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс, Боршоо авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс түр хааж, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох;

1.4. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хомсдол үүсгэхгүй байх үүднээс Алтанбулаг чөлөөт бүсэд тусгаарлалтын бүс, шилжүүлэн ачих байгууламжийг байгуулж бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн эм, эмийн бүтээгдэхүүн, өндөг, жимс, жимсгэнэ зэрэг түргэн гэмтэж, муудах бараа бүтээгдэхүүнийг уг талбайд шилжүүлэн ачих зохион байгуулалтын арга хэмжээг авах, бэлтгэл ажлыг хангах;

1.5. Олон улсын импортын ачааг төмөр замаар тээвэрлэх талаар ОХУ-ын холбогдох байгууллагуудтай дипломат шугамаар тохиролцох, тогтмол температур

шаардагдах хүнсний бараа бүтээгдэхүүн тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах;

1.6. Алтанбулаг хилийн авто замын боомтоор нэвтрүүлж байгаа олон улсын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр хугацаанд зогсоох зохицуулалтын арга хэмжээний талаарх мэдээллийг холбогдох олон улсын байгууллага, гадаад улсын тээвэр, худалдааны байгууллага, бизнес эрхлэгчид болон тээвэр зуучийн байгууллагуудад хүргэх;


1.7. Алтанбулаг боомтод халдвараас хамгаалах ариутгалын уурын шүршигч битүү төхөөрөмж, пункт байгуулахад шаардагдах зардлын тооцоог гаргах;

1.8. Хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй хилийн хяналтын байгууллагын албан хаагчид болон аймгийн эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг халдвар, хамгааллын нэг удаагийн хувцас хэрэгслээр бүрэн хангах, хувцас өмсөж, тайлах дадлага сургалт тогтмол зохион байгуулах;

1.9. Алтанбулаг худалдааны чөлөөт бүсэд тусгаарлалтын бүс байгуулах, Цагааннуур авто замын боомтын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зардлыг Сангийн ямаар хянуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

  
Я.СОДБААТАР